



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/618

Есөнбулаг

Химийн хорт болон аюултай бодисын  
асуудал хариуцсан салбар зөвлөлийг  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Химийн хорт болон аюултай бодистой холбогдож үүссэн аюул, осол, онцгой тохиолдлын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөө, салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиглахыг салбар зөвлөл (Г.Чинбат)-д даалгасугай.

3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, мэдээллийг тухай бүр танилцуулж ажиглахыг салбар зөвлөлд үүрэг болгосугай.

4. Тус захирэмж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/148 дугаар захирэмжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20.11.оны  
1.1 дугаар сарын 11-ны өдрийн 618 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

2023.09.12

Химийн хорт болон аюултай бодисын  
бодлого зохицуулалтын асуудал хариуцсан  
салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

- Салбар зөвлөлийн дарга: (Аймгийн Засаг даргын орлогч)  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн  
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн  
дарга)  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
бодлогын хэлтсийн дарга)  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн  
штабын орон нутгийн хамгаалалтын бэлтгэл,  
сургалтын офицер)  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн  
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн  
байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариусан  
мэргэжилтэн)  
(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)  
(Онцгой байдлын газрын дарга)  
(Эрүүл мэндийн газрын дарга)  
(Цагдаагийн газрын дарга)  
(Тагнуулын ерөнхий газрын аймаг дахь хэлтсийн  
Дарга)  
(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн  
хэлтсийн дарга)  
(Сумдын Засаг дарга нар)
- Нарийн бичгийн дарга: (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны  
бохирдол, хог хаягдал, химийн бодисын асуудал  
хариуцсан мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 20. Доны  
11 дүгээр сарын 17 ны өдрийн 618 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДЛААР МЭРГЭЖЛИЙН САНАЛ,  
ДҮГНЭЛТ ГАРГАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Аймгийн нутаг дэвсгэрт химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан Салбар зөвлөл нь /цаашид "Салбар зөвлөл" гэх/ химийн хорт болон аюултай бодисын талаар төрөөс баримтлах бодлогыг орон нутагт зохион байгуулж, бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй ажиллана.

1.2. Салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд хяналт тавих тухай Базелийн конвенци /1996/, Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенци /2000/, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенци /2003/, бусад хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон мөн энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

1.3. Салбар зөвлөл нь ажлаа аймгийн Засаг даргад тайлагнана.

**Хоёр. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт**

2.1. Салбар зөвлөлийн дарга нь аймгийн Засаг даргын орлогч байна.

2.2. Салбар зөвлөл нь орон тооны бус нарийн бичигтэй байна.

2.3. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох хэлтэс, агентлаг, болон мэргэжлийн байгууллагын зохих албан тушаалтан орох бөгөөд бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга батална.

2.4. Салбар зөвлөл нь 7-гоос доошгүй гишүүнтэй байна.

2.5. Салбар зөвлөлийн зардлыг аймгийн Засаг дарга хариуцах бөгөөд тухайн жилийн төсөвтөө тусгаж санхүүжүүлнэ.

2.6. Салбар зөвлөл нь аймгийн Засаг даргын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамгыг хэрэглэнэ.

**Гурав. Салбар зөвлөлийн ажиллах журам**

3.1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь зөвлөлийн хурал байна.

3.2. Салбар зөвлөлийн хурлыг хагас жил тутамд хийж, ээлжит бус хурлыг Салбар зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

3.3.Салбар зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга, түүний эзгүйд Салбар зөвлөлийн гишүүн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга даргална.

3.4.Салбар зөвлөлийн хурлаар асуудал хэлэлцүүлэх байгууллага холбогдох материалаа зөвлөлийн нарийн бичигт хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлнэ. Хурлын материалыг хурал болохоос 5 хоногийн өмнө гишүүдэд тараана.

3.5.Салбар зөвлөлийн хурлыг гишүүдийн олонхи ирсэн тохиолдолд хуралдуулж, хурлын тэмдэглэлийг нарийн бичиг хөтөлж, хурал даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

3.6.Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, хурлаас аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, албан бичиг болон холбогдох байгууллагын шийдвэр, дүгнэлт, зөвлөмж гаргана.

3.7.Шаардлагатай тохиолдолд салбар зөвлөлийн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан эрдэмтэн, мэргэжилтэн, хүмүүсийг оролцуулж болно.

#### **Дөрөв. Салбар зөвлөлийн эрх, үүрэг**

4.1.1.Салбар зөвлөл дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.2.Химийн хорт болон аюултай бодисын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бодлого тодорхойлох, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал гаргах;

4.1.3.Монгол Улсын нэгдэн орсон химийн бодисын талаархи олон улсын гэрээ болон үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тухайн салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлтэд хяналт тавих;

4.1.4.Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн зөрчил, маргааныг шийдвэрлэхэд мэргэжлийн зөвлөмж, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлд мэдэгдэх.

4.1.5.Химийн хорт болон аюултай бодистой холбогдож үүссэн аюул, осол, онцгой байдал зарласан тохиолдолд хор аюулыг бууруулахад мэргэжил арга зүйгээр хангаж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;

4.1.6.Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, устгахад аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

4.1.7.Химийн хорт болон аюултай бодистой холбогдсон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, стандартыг мөрдүүлэх, хяналт тавих;

4.1.8.Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагсдын мэдлэг, чадвар, иргэдийн химийн хорт болон аюултай бодисын талаархи мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалт, суртчилгаа зохион байгуулах;

4.1.9.Бусад;

4.2.Салбар зөвлөл дараах эрхтэй байна:

4.2.1 Химийн хорт болон аюултай бодисын асуудлаар зөвлөмж, дүгнэлт гаргах, хяналт тавих ажлын хэсэгт холбогдох байгууллага, мэргэжилтэн, шинжээч, улсын байцаагч нарыг татан оролцуулах;

4.2.2. Химийн хорт болон аюултай бодисын чиглэлээр аливаа байгууллагаас гаргасан шийдвэр, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, химийн хорт болон аюултай бодисын аюулгүй байдлыг хангах бодлогод нийцэхгүй байна гэж үзвэл хүчингүй болгох, зогсоох санал, дүгнэлтээ зохих байгууллагад гаргах;

4.2.3.Химийн хорт болон аюултай бодистой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас шаардлагатай мэдээлэл, тайлан, судалгаа, баримт материалыг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах.

4.2.4. Химийн хорт болон аюултай бодисын ашиглалтад шалгалт, тооллого хийх, ажлын зураг авах, шинжилгээнд сорьц, дээж авах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад чөлөөтэй нэвтрэх;

4.2.5 Санал, дүгнэлт гаргахад шаардлагатай лабораторийн шинжилгээг дотоод, гадаадын лабораторид хийлгэх.

4.2.6. Холбогдох хууль тогтоомжинд заасан бусад эрхийг эдлэнэ.

\_\_оОо\_\_